



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/А97

Булган сум

### Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, Засгийн газрын 2021 оны "Босго үнэ шинэчлэн тогтоох тухай" 124 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймаг, "Эрдэнэт Үйлдвэр" Төрийн өмчит үйлдвэрийн газрын 2023 оны хамтран ажиллах гэрээнд тусгагдсан Дашинчилэн сумын ховор ан амьтанд биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх, доройтсон бэлчээрийг сэргээхэд шаардлагатай зардлыг батлагдсан төсвийн дагуу шийдвэрлэх ажлын 10,000,000 (арван сая) төгрөгийг иргэн Дашзэвэг овогтой Лувсандагватай гэрээ байгуулах эрхийг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д олгосугай.

2.Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг Дашинчилэн сумын иргэн (Д.Лувсандагва)-д үүрэг болгосугай.

3.Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж хүлээн авахыг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Алтаншагай), Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (А.Гантөмөр) нарт үүрэг болгосугай.

4.Ажлын санхүүжилтийг гүйцэтгэлээр олгохыг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ